



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/303

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021оны 259 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/292, А/525 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай.

2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/292, А/525 дугаар хамтарсан тушаалаар баталсан журмыг мөрдөж удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (Ц.Уранбямба), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг сунгасан хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210542